



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/100

Хархорин сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 8.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын 1 дугаар баг Од 1-7 тоотод байрлах 6209000305 нэгж талбарын 10028 м² газрыг Жаст-Ойл ХХК-ын хүсэлтийн дагуу "Мазаалай Петролиум ХХК"-д шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Газар эзэмшигч "Мазаалай Петролиум ХХК"-д газар эзэмших эрхийн гэрчилгээ олгож, гэрээ байгуулж, улсын бүртгэлд бүртгэхийг газрын даамал (Ч.Баттулга), (Э.Дэнсмаа) нарт даалгасугай.

3.Газрын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллахыг газар эзэмшигчид үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2013 оны А/151 дугаар захирамж, газар эзэмших эрхийн гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

401100193